



Д.Оюунбадрах, доктор (Sc.D), профессор,
НХУС-ийн зөвлөх профессор
П.Яньдий, доктор (Ph.D), НХУС-ийн багш

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” БА “ХӨХ СУДАР” РОМАН ДАХЬ МУХУЛАЙН ДҮРИЙН ХАРЬЦУУЛАЛ

Abstract: Many scholars of Mongolia researched The Secrete History of the Mongols and “Blue Chronicle” Novel from many sides. But comparative researches about artistic roles of both novels are rare. Therefore we wrote many serial articles. In this time, we aimed to compare Mukhulai’s role among roles in The Secrete History of Mongolia and Blue Chronicle Novel. Reason is that Mukhulai mobilized his all powers for Chinggis Khan from 15 years of age and advanced to the state minister.

He was knight minister which was fair for his Khan, became good friend for him, passed many war and battle of long time and raised his reputation in the world. Not only original smartness and hard effort but also his education under OulenEkh, Menleg Father and Chuluun Knight impacted him to become famous people in the history.

In consideration to creating this role, The Secrete History of the Mongols described Mukhulai’s role from political side, V. Injanash described him in “Blue Chronicle” Novel as famous warrior and knight after the Chinggis Khan. Reason of this description is related to historic condition of that time and the author arranged evidences about historic person and actions in accordance with his expressing idea.

Түлхүүр үг: түүхэн дүр, гарамгай жанжин, дүр дүрслэл, уран сайхны онцлог

Удиртгал

“МНТ” ба “Хөх судар” романыг монголын үе үеийн эрдэмтэд олон талаас нь судлан шинжилжээ. Гэхдээ уг хоёр зохиолын түүхэн хийгээд уран сайхны дүрүүдийн талаарх харьцуулсан судалгаа хомс тул бид цуврал болгон хэд хэдэн өгүүлэл бичсэн юм. Энэ удаа бид “МНТ” ба “Хөх судар” романы түүхэн хүмүүсийн дүрээс Мухулайн дүрийг харьцуулан

авч үзэхийг зорилоо. Учир нь Мухулай бол Чингис хааны албанд арван таван наснаасаа зүтгэж, төрийн сайд болтлоо дэвшсэн монголын төр нийгмийн зүтгэлтэн юм. Энэхүү дүрийг эдгээр түүхэн бүтээлд хэрхэн урлан бүтээснийг авч үзье.

Үндсэн хэсэг

Монголын төр нийгмийн зүтгэлтэн Жалайрын Мухулай 1171 онд мэндэлжээ. Бага балчраасаа эхлэн Чингис хааны албанд зүтгэх бөгөөд түүний эцэг энэ замынх нь эхлэлийг тавьсан юм. “МНТ”-д “...Чингисийг хаан болсны хойно Алтан улсын Ванган Чинсантай нийлэн Татарыг дайлсны дараа Жалайрын Гүн гуа, Мухулай Буха хоёр хөвгүүнээ Чингист уулзуулан:

*Босгоны чинь
Боол болтугай
Үүднээс чинь
Дутааж зайлвал
Элгий нь эмтэл”*

гэв. (Монголын нууц товчоо, х.86) Ингэж эзэн сайд хоёр учирсан түүхтэй.

“Хөх судар”-т “...Тайзу Балгуу хорооноос гарч Дэлгэт баяны нутгийн ойр хүрч ирэн, хэдэн мянган “Хөх сударал хариулж суусан хүүгээс оргуулыг асуувал “Чи барилдаад дийлбэл би зааж өгнө.” хэмээвээс Тайзу хүүг давсанд тэр хүү “Боржигод овгийн Тэмүжин гэгч бодтойяа тэнгэрийн хөвүүн аж. Би эзэн чиний морины хөтөч болж хүчээ өргөж их үйлийг бүтээнэ” хэмээгээд нөхөр болон Тайзутай хамт Балгуу хорооноо ирэв.” (В.Инжинаш, х.109-112) хэмээснээс харахад Мухулай Тайзу хоёрын нөхөрлөснийг В.Инжинаш өөрөөр дүрслэн бичжээ. Ингэж хоёр залуугийн учран золгож, уулзан танилцаж буй байдлыг туульсын хоёр их баатрын дүрээр гаргахын хамт бодит байдлаас зөрүүлж угийн заяат тэнгэр эзэнтэйгээ хувь төөрөг заяа тавилангаараа учирцагасан гэсэн

санааг илэрхийлжээ. Энэ цаг мөчөөс эхлэн эзэн сайд хоёр насан эцэстлээ үнэнч анд нөхрийн ёсоор амраглан ханилж олон жилийн дайн тулааныг даван туулж нэр сүрээ дэлхий дахинд алдаршуулсан эзэн хаан, баатар сайд болцгоосон юм. Мухулай арван таван наснаасаа Чингис хааны албанд зүтгэж эхэлсэн бөгөөд төрөлхийн авхаалжтай хичээнгүй хүү дотоод үйлэнд Өэлүн эх, Мэнлэг эцэг, Чулуун зэрэг хөлөг баатруудын хатуу гараар суралцсан гэж хэлж болно.

Татар Мэргэд Хэрэйдийн ханлигийг нэгтгэх үед байлдааны хэд хэдэн томоохон ажиллагааг зохион байгуулахад Мухулай идэвхтэй оролцжээ. Тэрээр хорь хүрэхгүй насандаа дөрвөн хөлөг баатрын нэг болж гучин насны босгон дээр есөн өрлөгтний тоонд багтан түүнээс хойш бараг олон тушаалд дэвшсээр байсан юм. Нэгэн өдөр Чингис хаан дотоод есөн сайдынхаа зургаан сайдтайгаа яваад нэг зүүд зүүдэлдэг бөгөөд хэрвээ энэ зүүд нь үнэн бол зургаан сайд минь, та нар юу хийх вэ? гэхэд Мухулай:

*“Дайсныг дарж
Олзыг оруулж...
...Байлдаан бүхэнд ялсан
Баяртай сайхан мэдээг
Баатар чамдаа хүргэе”*

гэдэг. Энэхүү хэлсэн амандаа хүрч чадсан Мухулайг Чингис хаан магтан:

*Дайсныг даралцаж
Олзыг оруулцаж...
...Дайсны хөрөнгөөс
Хугархай зүү гээлгүй
Хураан авч ирсэн
Жалайрын сайн Мухулай минь*

(Монголын нууц товчоо, х.104-105) хэмээсэн хэсэг “Хөх судар” романд байхгүй байна. Үүнийг зохиолчийн үзэлтэй холбон тайлбарлаж болох юм.

“МНТ”-д Чингис хааны цэргийн их үйлсийг Хубилай захирдаг бол “Хөх судар”-т энэ үйл хэргийг Мухулай жанжин удирдан жолооддог. Жишээ нь: Тайзугийн сарлагийг авах аргыг Жонон Мухулай зохион байгуулдаг бөгөөд тэрээр өглөө эрт уул тал мөрөн голын байдлыг шинжээд: *“сарлаг мөрний ус хуучин урссан заагаасаа доош орсон байхыг үзээд цацардаа ирж Чулуун Зэв хоёрт 500 цэрэг өгч энэ сарлаг мөрний голын ус хөөстэй урсах ёсгүй. Энэ газар уул, хад элбэг тул лав бөглөх таглах гэм буй. Хэрвээ тийм бол сахисан цэргийг хаагаад*

миний тэмдгийг сонсоод даруй сэтэлж илгээ гэв. Энэ үед Мухулай зальт хааны II сул талыг хэлж өөрсдийн эр цэргээ зоригжуулж байгаа зэрэг нь...” (В.Инжинаш, х.734-737) түүнийг хэр сайн цэргийн жанжин болохыг батлан харуулж байна. Энэ мэт олон дүрслэлээс харахад В.Инжинаш Мухулайг арга ухаантай, маш их авьяаслаг цэргийн гарамгай жанжин, өөрийн гэсэн үзэл бодолтой нэгэн үеийн баатарлаг их хүнээр дүрслэн уран сайхны дүр бүтээжээ.

“МНТ”-д Нэгдсэн гүрэн байгуулагдсаны дараа Чингис хаан Мухулайд зарлиг болгож: *“... Мухулайг ургийн урагт хүртэл улс гүрний гоо ван болгоё ...” гэж Гоо вангаар өргөмжлөөд, зүүн гарын Хараун-Жидуны хавийн түмнийг мэдтүгэй.*” (Монголын нууц товчоо, х.181) гэж зарлиг болгодог. Ингэж “Гоо ван” хэмээн өргөмжилсний учир нь тэр үнэхээр идэр залуухан гоо үзэсгэлэн төгс төгөлдөр байхын сацуу оюун ухаан мэдлэг чадвар бусдыг удирдан чиглүүлэхийн хувьд тухайн үедээ хосгүй нэгэн байснаас энэхүү алдрыг хүртсэн бололтой. Тэгвэл “Хөх судар” романд Чингис хаан ор суугаад *“Мухулайг Жонон түшмэдийг тэргүүлэх Юуваншувэй, зүүн баруун түмнийг захирах мөрийн жанжнаар өргөмжлөв.”* (В.Инжинаш, х. 1253) Эндээс үзэхэд “МНТ”-д Мухулайг Гоо вангаар өргөмжилсөн бол “Хөх судар”-т Юуваншувэй хэмээх цолыг олгосон байна. Энэ хоёр цол хэргэм нэрнийхээ хувьд ялгаатай боловч гүйцэтгэх үүрэг эрх мэдлээрээ адилхан ажээ. Гэхдээ В.Инжинаш Мухулайд олгосон Юуваншувэй цолынхоо өмнө “цэргийн түшмэдийг тэргүүлэх” гэдэг үгийг нэмсэн нь түүнийг шууд цэргийн гарамгай жанжин гэдгийг тодотгон дүрсэлсэнтэй холбоотой юм. Үүнийг Тайзугийн цэргийн бүх үйл ажиллагааг Мухулай жанжин удирдан жолоодож байгаагаас харж болно.

Энэ дүрийн тухай түүхч Т.Мандир *“Мухулай төрийн ерөнхий сайдын зиндаанд эсвэл гадаад үйлийг эрхлэх сайдын хэмжээнд ажиллаж байсан бололтой. Энэ үеэс Мухулайн амьдралд дипломат ажил зонхилсон гэж үзэх үндэс байна. Бичгийн болон ёслолын албанаас бүрдсэн гадаад харилцааны төрийн дээд байгууллагыг Мухулайн оролцоотойгоор анх байгуулсан юм. Гадаадтай харилцах дээд эрхийг хаан өөрөө барих тул тус байгууллага гадаад явуулах, дайн ба найрамдлын асуудал байвал их хуралдайд оруулах ажлыг гүйцэтгэж байжээ.”* (Т.Мандир, х.45) хэмээн онцлог дүгнэсэн байдаг.

“МНТ”-д Тэмүжин Алтан улсыг дайлах нь урт хугацааны асуудал гэдгийг ойлгож байсан учраас өмнөдийн хэргийг бүхэлд нь Мухулайд даалгадаг. Ингээд Мухулай Алтан улсыг мөхөөхийн тулд Сүн улсыг ашиглах боломжтой гэсэн Чингис хааны саналд үндэслэн тэдэнтэй элчин сайдын хэмжээнд хэдэнтээ уулзаж энэ хэрэгт татан оруулж чадсан нь тухайн үедээ дипломатын томоохон амжилт болсныг өгүүлжээ. Эндээс харахад бид түүхч Т.Мандирын дүгнэлттэй санал нийлж байна.

“Хөх судар”-г *“Алтан улсыг дайлсны дараа Цагаадай ихэд баярлаж хотод орж бүгдийг аваачтугай хэмээхэд Юваншувай Мухулай эдүгээ санхүүг хураахаас олон иргэний сэтгэлийг нь эд амуу түгээн өгч авбаас эдгээр иргэн гэдрэг харин манай цэргийг хүсэх болмуй. Алтан улсын алба авч байсан иргэнд бид эдүгээ амуу түгээн сэтгэлийг нь авбаас маньг эргэсэн хойно хэдий алтнаас ирж цэрэг хотыг сахивч лав өөрийн цэргээ дарж манай цэрэгт тусалмуй. Ийн болбоос хотыг цэрэг үлдээн эс сахиулавч сахиулсан иргэний сэтгэлийг авах арга. Хотын олон иргэний сэтгэлийг алдваас хожим дайлахад маш бэрх болмуй.”* (В.Инжинаш, х. 1398) хэмээн хэлсэн нь маш ухаалаг төрийн холч хараатай, мэргэн ухаан бодолтой, аливаа зүйлийн наад цаадахыг ялган салгаж чадах ухаалаг нэгэн болох нь тодорхой харагдаж байна. Иймэрхүү жишээг уг хоёр зохиолын хаанаас ч гэсэн сонгон авч бичих боломжтой юм.

В.Инжинаш Мухулайн дүрийг урлан бүтээхдээ жанжин хүнд байж болох бүхий л шинжүүдийг багтаан уран сайхны дүр бүтээсэн байна. Үүний илрэл нь Х.Шагдар “Чингис-цэргийн гарамгай жанжин” хэмээх бүтээлдээ жанжин хүний шинжийг дараах дөрвөн анги, арван шинжээр томьёолсон байна. Үүнийг харуулбал:

А. Мэргэн цэцэн

1. Авьяас
2. Бүтээлч уян хатан сэтгэхүй
3. Урьдчилан харах чадвар
4. Зохион байгуулах чадвар
5. Зөн билиг

Б. Баатар чанга

6. Шийдмэг
7. Шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээхэд бэлэн байх чанар
8. Эр зориг

В. Бат өршөөлт

9. Өрөвч нинжин сэтгэл

Г. Туришлага

10. Туршлага

хэмээн үзсэн байна. Ингээд эдгээр шинж “Хөх судар” роман дахь Мухулайн дүрд байгаа эсэхийг авч үзье.

1. **Авьяас** бол Мухулайн цэргийн жанжны шинж мөн. Монголчууд 15 наснаас нь дайнд дагуулж, 17 наснаас нь байлдаанд оруулдаг байв. Мухулай ч 15 наснаасаа Чингис хааны их үйлсийг бүтээхэд гар бие оролцохын сацуу цэргийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж байсан юм. “Хөх судар”-ын 3-р бүлэгт Тайчууд Татар Самуун зэрэг аймаг нийлж Беттэй тулалдах үед анх удаа Мухулай цэргийг удирдан уран арга авьяас билгийнхээ ачаар өндөр их ялалтыг байгуулсан нь цаашид бүтээх амжилтуудынх нь зөвхөн эхлэл нь байлаа. Чингисийн хийсэн аян дайны амжилтын дийлэнх илүү хувьд нь Мухулай гар бие оролцож байсан нь түүний авьяаслаг жанжин болохыг харуулж байна.

2. Мухулай уян хатан бүтээлч сэтгэхүйтэй жанжин мөн. Чингис аливаа дайн байлдааны бодлого төлөвлөгөөг гаргахдаа Мухулайтай зөвшин хэлэлцдэг байлаа. Жишээ нь: Мухулай Тайчууд Татар нартай байлдахын өмнө Чингистэй ирж уулзан туг, хэнгэрэг гуйлин бэлдүүлэх хэрэгтэй хэмээхэд нь Чингис учрыг асуувал, “Эдгээрийг бэлдэж хэрэглэснээр цаанадаж бусдын чих нүдийг айлгана, наанадаж өөрийн цэргийн хүн олон болсноор үг захируулах харилцан сонстохгүй тул дохио чимээ болмуй” гэхэд Тайзу мал адуулж мунгинан явсан Мухулай хөвгүүнд энэ зэргийн ухаан бодлого зориг байхыг мэдэж ихэд гайхан баярлав. Цэрэг дайлах аргыг түүнээс асуувал: “Тухайн байдалд нийлүүлэн угтаж хувилгая. Урьдаж тогтсон задарвал болохгүй” хэмээв (В.Инжинаш, х.165) гэснээс тодорхой байна. Үүнээс гадна Мухулайн уян хатан зан чанар нь дайны талбар дээр илүү их илэрдэг байсны нэг илрэл нь Татар Тайчууд нартай байлдах үед *“Тайзу бага байхад нь урваж одсон Хулжиньг хараад дайран орох гэхэд нь Мухулай хориглон зогсоож, Тайчуудын цэрэг 3 удаа дайрсан хойно цэргээ байлдаанд оруулав. Хожим нь энэ тухайгаа тайлбарлахдаа аливаа цэргийн уур өглөө эрт хүчирхэг, өдөр алжаангуй, наран ташваас уур буумуй гэв. Бид тэдний цэргийн алжаангуй болохыг хүлээж манай цэргийн будааг идүүлэн чийрэг болгож тулалдаанд оруулсан билээ”* (В.Инжинаш, х.171) хэмээн хэлж байдаг. Энэ мэт бие даан

чөлөөтэй сэтгэн хариуцлагыг өөртөө үүрэн уян хатан зөв шийдвэр гаргаж байдаг нь уян хатан шинжийг нь батлан харуулж байна.

3. Мухулайд байгалиас заяасан **зөн билэг** нь урьдчилан харах увдисыг хайрлажээ. Урьдчилан харах чадвар нь нөхцөл байдлын талаарх гүн гүнзгий мэдлэг мэдээлэл, тэр мэдээллийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх оюуны чадавхийн үр бүтээл юм. Мухулай Сарлаг улстай байлдахын өмнө голын усны голдирлыг харж энэ голын эхийг боож тагласан байж магадгүй хэмээн хүн явуулж байгаа нь түүнийг ямар их мэдрэмжтэй болохыг харуулж байна.

4. **Зохион байгуулах чадвар** Мухулайд буй өвөрмөц бас нэгэн шинж юм. Тэрбээр Тайзутай хавсран цэргийн бүхийлүйлажиллагааг зохион байгуулж байсан бөгөөд Сартуул улстай байлдахад гол үүргийг гүйцэтгэснээс гадна Тайзуг Хе вантай ураг барилдахаар явахад нь урьдчилан сэргийлж цэргийг зохион байгуулсан зэрэг нь дээрх шинжийг нотлон харуулж байна. Энэ мэт жанжин хүнд байж болох бүхий л шинжийг Мухулайн дүрээс харж болно. Тэгэхлээр энэхүү дүр “Монголын нууц товчоо” дахь Мухулайн дүрээс эрс ялгаатай өвөрмөц дүр болжээ.

5. **Шийдмэг** зан бол баатар чанга жанжны нэг өвөрмөц шинж юм. Тэрээр хонь хариулж байхдаа Чингистэй уулзангуутаа юу ч бодолгүй шууд л түүнийг даган хамт ирсэн хийгээд Хонгорзулыг дайсан гэлгүй мэдлэг чадварыг нь үнэлэн дэргэдээ авч охиноо болгож байгаа зэрэг нь эл шинжийн баталгаа юм.

6. Гаргасан **шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээж чадах чанар** жанжин хүнд байх ёстой өвөрмөц онцлогийн нэг мөн. Мухулай сул цэргээсээ Магуудын Хуйлдар хошуучийг олоод их л баярлав. Тэгээд Тайзуд сөгдөн цэргийн жононгийн тушаалд байх атал энэ мэт хүнийг таньсангүй, өөрийгөө буруутган ял тохоод Чингис төдийлөн хэрэгсээгүй байхад өөртөө өгсөн ялаа өөрчлөлгүй хариуцлагыг хүлээн ялаа цайруулж байдаг.

ДҮГНЭЛТ

Эцэст нь тэмдэглэхэд, монголын эртний уран зохиолын гол дурсгал болох “Монголын нууц товчоо”-д Мухулайн дүрийг улс төрч талаас нь дүрсэлсэн бол “Хөх судар” романд В. Инжинаш энэхүү түүхэн хүний дүрийг Чингис хааны дараа орох, цэргийн урлагийг төгс эзэмшсэн гарамгай жанжин гэдэг талаас дүрслэн бичсэн нь дээрх баримтаас харагдаж байна. Ингэж дүрслэн бичсэний гол шалтгаан нь тухайн үеийн түүхэн нөхцөлтэй холбоотой төдийгүй үнэн, түүхэн хүн, үйл явдлын баримтыг зохиолч өөрийн хэлэх гэсэн санаандаа зохицуулж, уран сайхны өвөрмөц дүр бүтээсэн байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Инжинаш, В. (1991). *Хөх судар*. /I, II, III дэвтэр / Хөх хот.

Дамдинсүрэн, Ц /эмх/. (1990). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар.

Мандир, Т. (1990). *Хорин нэгэн хөрөг*. Улаанбаатар

Шагдар, Х. (1996). *Хөх судар ба монгол цэргийн урлагийн зарим асуудал*. / “Монголын цэргийн түүхийн судлал: өнөө ба ирээдүй” / Улаанбаатар.

Шагдар, Х. (2002). *Чингис цэргийн гарамгай жанжин*. / “Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл” / Улаанбаатар.

Хишигсүх, Б. (2005). *Хөх судрын хоёр эхийн утга, уран сайхны харьцуулсан судалгаа*. Улаанбаатар.